

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.20, 13.100

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүр хамгаалах хэрэгсэл	MNS 5624:20XX
Occupational safety and health. Personal protective equipment. Head protection. Face protection	MNS 5624:2006-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь үйлдвэрлэл, үйлчилгээний явцад тохиолдож болзошгүй механик биет, гэрэл, дулаан, тоос шороо болон бусад төрлийн аюулаас хүний нүүрийг хамгаалах зориулалт бүхий нүүр хамгаалах хэрэгсэлд хамаарна. Гагнуурчны баг энэ стандартад хамаарахгүй.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 10256, Нүүр хамгаалах хэрэгслийн норм EN 166, 397, 1731
MNS 4931, Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал

3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1

Хувийн хамгаалах хэрэгсэл

Хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл.

3.2

Нүүр хамгаалах хэрэгсэл

Үйлдвэрлэлийн явцад үүссэн жижиг биет, гэрэл, химийн бодис, дулааны нөлөөллөөс нүүр болон эрхтэн тогтолцоог хамгаалах зориулалтын хэрэгсэл.

4 Нүүр хамгаалах хэрэгслийн бүтэц

4.1 Дан нүүр хамгаалах хэрэгсэл

4.1.1 Дан өнгөт нүүр хамгаалах хэрэгсэл

4.1.1.1 Толгойд өмсөх хагас дуулга

4.1.1.2 Нүүрэвчийг толгойд тохируулах цагариг

4.1.1.3 Хөлс шингээгч жийргэвч

4.1.1.4 Өнгөт нүүрэвч

4.1.2 Дан тунгалаг нүүр хамгаалах хэрэгсэл

4.1.2.1 Толгойд углах хагас дуулга

4.1.2.2 Толгойд тохируулах цагариг

4.1.2.3 Хөлс шингээх жийргэвч

4.1.2.4 Тунгалаг нүүр хамгаалах хэрэгсэл

4.2 Дуулгатай нүүр хамгаалах хэрэгсэл

4.2.1 Дуулгатай тунгалаг нүүр хамгаалах хэрэгсэл

4.2.1.1 Дуулга

4.2.1.2 Дуулганд тохируулах цагариг

4.2.1.3 Хөлс шингээх жийргэвч

4.2.1.4 Тунгалаг нүүрэвч,

4.2.2 Дуулгатай өнгөт нүүр хамгаалах хэрэгсэл

4.2.2.1 Дуулга

4.2.2.2 Дуулганд тохируулах цагариг

4.2.2.3 Хөлс шингээх жийргэвч

4.2.2.4 Өнгөт нүүрэвч

4.2.3 Дуулгатай металл торон нүүр хамгаалах хэрэгсэл

4.2.3.1 Дуулга

4.2.3.2 Нүүрэвчийг дуулганд тохируулах цагариг

4.2.3.3 Хөлс шингээх жийргэвч

4.2.3.4 Металл торон нүүрэвч

5 Ерөнхий зүйл

5.1 Зорилго

Энэ стандартын зорилго нь жижиг механик биет, гэрэл, дулаан, химийн бодисоос нүүр хамгаалах хэрэгсэлд тавих шаардлагыг тогтооход оршино.

5.2 Ерөнхий шаардлага

5.2.1 Нүүр хамгаалах хэрэгсэл нь хэрэглэгчийн нүүрний хэлбэрт зохицсон, хараа хязгаарлахгүй, амьсгалахад саад учруулахгүй, хөнгөн, өнгө үзэмжтэй, хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байна.

5.2.2 Нүүр хамгаалах хэрэгсэл нь хүний биед хоргүй, хэрэглэхэд дарамтгүй, хөнгөн, хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байна.

5.2.3 Нүүр хамгаалах хэрэгслийн нүүрэвч нь механик цохилт, галд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.

5.2.4 Харшил өгөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан материалаар хийсэн

байна.

- 5.2.5** Нүүр хамгаалах хэрэгсэл нь спирт, зориулалтын ариутгагч уусмалаар цэвэрлэх боломжтой байна.
- 5.2.6** Нүүр хамгаалах хэрэгсэл нь Олон улсын болон MNS 4931 шаардлагыг хангасан байна.

5.3 Тусгай шаардлага

- 5.3.1** Тунгалаг нүүр хамгаалах хэрэгсэл нь нүүрэнд ирэх механик биетийн хэмжээ, шинж чанараас шалтгаалан 12м/сек-ээс 190 м/сек-ийн хурдтай цохилтыг тэсвэрлэх чадвартай, 1 мм-ээс 5 мм-ийн зузаантай байна.
- 5.3.2** Өнгөтэй нүүр хамгаалах хэрэгсэл нь хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалан гэрлийн хүчийг 1DIN-ээс 6 DIN бууруулах чадвартай байна.
- 5.3.3** Металл торон нүүр хамгаалах хэрэгсэл нь нүүрэн дээр унах томхон хатуу биет, жижиг халуун биетээс хамгаалах чадвартай байна.
- 5.3.4** Нүүр хамгаалах хэрэгсэл нь толгой, нүд, сонсгол хамгаалах хэрэгслүүдтэй иж бүрдлээр хийгдсэн байх ба дуулга нь толгойг цохилтын хүчнээс хамгаалах, чихэвч нь шуугианыг 30 дБ-аас 35 дБ хүртэл бууруулах, Нүүр хамгаалах хэрэгслийн гэрэл бууруулах чадвар нь стандартын 5.3.2- той адил байна.
- 5.3.5** Нүүр хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт нь “А” хавсралтад заасантай тохирч байна.

6 Хэрэглэх ба шалгах арга

6.1 Дан нүүр хамгаалах хэрэгслийг хэрэглэх ба шалгах

- 6.1.1** Дан нүүр хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөл тохирч буй эсэхийг тогтоосны дараа нүүр хамгаалах хэрэгслийн өмсгөл (цагариг)-ийг толгойдоо тохируулж, нүүр хамгаалах хэрэгслээ хөдөлгөөнгүй бэхэлнэ.
- 6.1.2** Нүүр хамгаалах хэрэгслийг дээш, доош тэнхлэгээр нь хөдөлгөж шалгаад түгжээг түгжиж, ажлаа эхэлнэ.

6.2 Дуулгатай нүүр хамгаалах хэрэгслийг хэрэглэх ба шалгах

Толгой хамгаалах хэрэгсэл нүүр хамгаалах хэрэгслийн зохион байгуулалт, техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөлийн тохиромж зэргийг шалгасны дараа нүүр хамгаалах хэрэгслээ толгой хамгаалах хэрэгсэлд тогтоогч бүсийн тусламжтай угсарч, толгойдоо хөдөлгөөнгүй бэхэлж, нүүр хамгаалах хэрэгслийг түгжинэ.

7 Хадгалах нөхцөл, хугацаа

Нүүр хамгаалах хэрэгслийг 70%-ийн чийгшилтээс бага, 0⁰C-аас 20⁰C-ийн дулаанд, стандартын сав баглаанд хадгална. Нүүр хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал алдагдсан үед солино.

8 Анхаарах зүйл

- 8.1** Нүүр хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт, хөдөлмөрийн нөхцөл бүрэн тохирч байгаа эсэх.
- 8.2** Нүүр хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, хяналтын албаны зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл хоорондоо бүрэн тохирч буй эсэх.
- 8.3** Ашиглах, хэрэглэх арга нь энэхүү стандартын дагуу явагдаж байгаа эсэхийг байнга шалгаж байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

Хүснэгт А.1

Нүүр хамгаалах хэрэгслийн техникийн үзүүлэлт

№	Ангилал	Техникийн үзүүлэлт
1	Тунгалаг нүүр хамгаалах хэрэгсэл	Механик биет /ус, төмрийн үртэс/-ийн хурд 12 м/секундээс шалтгаалан 1- 5мм зузаан байна. Нүүр хамгаалах хэрэгслийн харах талбай 200 х 200 мм хэмжээтэй байна.
2	Өнгөт нүүр хамгаалах хэрэгсэл	Гэрлээс хамгаалах өнгөтэй нүүр хамгаалах хэрэгсэл нь гэрлийн хүч /1-6 DIN /-ээс шалтгаалан ногоон, шар, хар ногоон, хар өнгөтэй болон зузаан нь 1мм-ээс 5мм хүртэл байна. 1000 хүртэлх вольтын хүчдэлтэй цахилгаан нумын гэрлээс хамгаалах нүүр хамгаалах хэрэгсэл нь гадуураа хөнгөн цагаанаар бүрсэн байна. Нүүр хамгаалах хэрэгслийн харах талбай 200х200 мм хэмжээтэй байна.
3	Металл торон нүүр хамгаалах хэрэгсэл	Нүүрэн дээр унах жижиг галт биетээс хамгаалах зорилгоор зэвэрдэггүй гангаар 0.1 мм-0.6 мм-ийн алслалтай сүлжиж хийсэн ба сүлжээс нь харааны талбайд саад учруулахгүй байна Нүүр хамгаалах хэрэгслийн харах талбай 200х200 мм хэмжээтэй байна.